

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ЯВУУЛАХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ 2016 ОНД
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2016-11-11

Алтай хот

Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, орон нутгийн гаргаж буй шийдвэрт иргэдийн оролцоо саналыг тусгах, Төрийн байгууллагын үйл ажиллагааг ил тод болгох, Төсвийн болон худалдан авах ажиллагааны ил тод байдал, иргэдийн өргөдөл гомдол хүлээн авах шийдвэрлэх, мэдээлэл хүргэх ажиллагааг боловсронгуй болгох, төрийн албан хаагчдын манлайлах ур чадвар болон шударга байдлыг дээшлүүлэх, хүүхэд залуучуудын дунд авлигын эсрэг, шударга ёсны талаар сурталчилгаа нөлөөллийн ажлыг зохион байгуулах зэрэг ажлыг нэн тэргүүний зорилт болгон тавьж ажиллалаа.

Нэг. Удирдлага зохион байгуулалт, авлигатай тэмцэх санал, санаачилга, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэх:

1.1.Үйл ажиллагааны төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын чиглэлээр:

Иргэний оролцоотой, хариуцлага, хяналтын мехнаизмтай, авлигаас ангид, ил тод нээлттэй засаглалыг бэхжүүлэх зорилгоор Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Монгол Улсын Үндсэн хууль болон мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиар баталгаажсан иргэдийн мэдээлэлтэй байх эрхийг хангуулж, төр түүний байгууллагаас үзүүлж буй төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй энгийн ойлгомжтой байдлаар хүргэх, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд хуульд заасан хариуцлага хүлээлгэх хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн даргын 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 5/132 дугаар албан бичгээр аймгийн авлигын эсрэг төлөвлөгөөний 2016 оны төслийг Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст хүргүүлэн арга зүйн зөвлөгөө авч аймгийн Засаг даргын 2016 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/65 дугаар захирамжаар батлуулан төлөвлөгөөний зорилт арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа.

Аймгийн засаг даргын 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан даалгавраар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгож, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа.

/Эх сурвалж: www.govi-altai.gov.mn-Ил тод байдал-Авлигатай тэмцэх төлөвлөгөө –цэснээс үзэх, аймгийн Засаг даргын 2016 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн 02 дугаар албан даалгаврыг тайланд хавсаргав./

Төсвийн сахилга батыг сайжруулах зорилгоор Жил бүр зохион байгуулагддаг “Санхүүгийн ажилтны нэгдсэн семинар зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, 2016 оны 05 дугаар сарын 26-ны өдөр зохион байгууллаа.

/Эх сурвалж: Аймгийн Засаг даргын захирамж, зөвлөгөөний хөтөлбөр, зөвлөмжийг тайланд тайланд хавсаргав./

Төрийн албанд ажиллаж буй эмэгтэйчүүдийн манлайлах ур чадварыг хөгжүүлэх, өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжийг бий болгон бие биеэсээ суралцах, орон нутгийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн форум”-ийг 2016 оны 05 дугаар сарын 23-нд зохион байгууллаа.

Тус форумд аймгийн төвийн 54 албан байгууллагын 503 төрийн албан хаагч эмэгтэй оролцож, Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн манлайлал, Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн ёс зүй, төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломж, төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн харилцаа гэх мэт сэдвээр сэдвээр мэдээлэл хийж, харилцан санал солилцлоо.

/Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2016 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/223 дугаар захирамж, форум зохион байгуулах удирдамж, оролцсон албан хаагч эмэгтэйчүүдийн бүртгэл зэрэг материалыг тайланд хавсаргав./

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2016 оны 06 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд тус аймгийн 17 сум 2 тосгонд Төрийн байгууллагуудын нээлттэй өдөрлөг–өрх бүрт арга хэмжээг аймгийн ЗДТГ, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Боловсрол соёлын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Улсын бүртгэл, статистикийн газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгууллаа.

/Эх сурвалж: баталсан удирдамжийг тайланд хавсаргав./

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 141 дүгээр тогтоолын дагуу “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв” -ийг байгуулах бэлтгэл ажил хангагдаж, тус төвийн үйл ажиллагааны нээлтийг хийлээ.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв нь газрын харилцаа, барилга хот байгуулалт, мэргэжлийн хяналт, хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээ, нийгмийн даатгал, татвар, иргэн болон хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр нийт 156 үйлчилгээг үзүүлэн ажиллаж байгаа бөгөөд цаашид бусад төрлийн үйлчилгээнүүдийг нэмж үзүүлэх боломжтой юм.

Ийнхүү нэг дороос төрийн үйлчилгээг иргэдэд нээлттэй, хөнгөн шуурхай, чирэгдэл, хүндрэлгүй хүргэх боломж бүрдэж байна.

Төрийн байгууллагууд өөрсдийн хийж хэрэгжүүлсэн ажлаа иргэд, олон нийтэд танилцуулах, сурталчилах зорилгоор “Засгийн газрын 100 хоног” арга хэмжээг 09 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын баатар М.Жанчивын талбайд зохион байгууллаа.

Тус арга хэмжээний ерөнхий зохион байгуулагчаар аймгийн Засаг даргын Тамгын газар, хамтран зохион байгуулагчаар Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагууд, төсөвт байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд, сумдын Засаг даргын Тамгын газар ажиллалаа.

“Засгийн газрын 100 хоног” арга хэмжээнд 18 сумын 90 төрийн байгууллага, аймгийн төвийн 35 албан байгууллагын 399 төрийн албан хаагч, 400 гаруй иргэн оролцсон бөгөөд үйл ажиллагааг нээж аймгийн Засаг дарга С.Гансэлэм үг хэлж, төрийн үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг хангаж, олон нийтэд ойлгомжтой арга хэлбэрээр ажиллахаа мэдэгдэж, боловсруулагдаж байгаа үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн төсөлд иргэд олон нийт санал өгч хамтран хэрэгжүүлж ажиллах талаар уриаллаа.

Тус арга хэмжээний үеэр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн цогц бодлого, хөгжлийн бодлогын бусад баримт бичгүүдэд тулгуурлан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулж байгаатай холбогдуулан иргэдээс аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт болон аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2017 онд хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг танилцуулан санал авлаа.

Аймгийн Засаг дарга тус хөтөлбөрийг боловсруулахад өөрсдийн үнэтэй саналаа өгч, аймгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох чухал баримт бичигт тусгуулахыг уриаллаа.

Төрийн байгууллагууд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд авч хэрэгжүүлэх ажлын санал асуулга, сэтгэл ханамжийн судалгааг давхардсан тоогоор 1945 иргэнээс авч, 180 гаруй нэр төрлийн 3000 гаруй гарын авлага материалыг иргэдэд хүргэлээ.

[/www.govi-altai.gov.mn](http://www.govi-altai.gov.mn)-цаг үеийн мэдээ –үйл явдлын мэдээ –цэснээс үзнэ үү. Удирдамж, арга хэмжээний дараалал зэрэг холбогдох баримт бичгийг тайланд хавсаргав./

Орон нутгийн төсвөөс Авлигын эсрэг үйл ажиллагаанд нийт 76,0 сая төгрөгийг удирдлагын шийдвэрээр тухай бүр гаргаж, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, төрийн албан хаагч иргэдэд зориулсан сургалт явуулах, уралдаан тэмцээн зохион байгуулах зэргээр урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд зарцуулж ажиллалаа.

№	Зохион байгуулсан ажил	Тушаал шийдвэрийн дугаар, огноо	Мөнгөн дүн /төг/	Тайлбар
1.	Авлигын эсрэг олон улсын өдөр, Хүний эрхийн өдрийг тохиолдуулан иргэд олон нийтэд Үндсэн хуулиар бататгасан хүний эрхийн үзэл санаа, шударга ёс хүний эрхтэй салшгүй холбоотой болох талаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Хүний эрх ба хууль тогтоомжийн хэрэгжилт” эссэ нийтлэлийн уралдаан мөн авлигын эсрэг ойлголт сэтгэл зүйг бий болгох зорилгоор “Авлигын үйлдэл хүний эрхийг зөрчих хэрэгсэл болох нь” сэдэвт гар зургийн уралдаан тэмцээнийг зохион байгуулах. Аймгийн Аудитын газартай хамтран “Авлигын эсрэг бид хамтдаа” дэвжээ тэмцээнийг Шүүх, Хууль сахиулах байгууллагуудын ажилтнуудыг оролцуулан зохион байгуулна.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Даргын 2015 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/48 дугаар тушаал	145000 төгрөг Аймгийн ИТХ-аас 300000 төгрөг	“Авлигын эсрэг бид хамтдаа” дэвжээ тэмцээнд багуудаас оролцооны мөнгө авч зохион байгуулсан.
	Төрийн бодлогын хэрэгжилт аймгийн Засаг даргын Тамгын газраас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс санал асуулга авч, хэрэглэгчийн үнэлгээ хийлгэсэн	Аймгийн Засаг даргын 2015 оны А/368 дугаар захирамжаар	1500000 төгрөгийг орон нутгийн төсвийн төрийн өмнөөс гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлаас	
2.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад “Ухаалга харилцаа-амжилтын эхлэл” сургалтыг зохион байгуулсан	Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/05 дугаар тушаалаар	468000 төгрөг	
3.	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах сарын аян 2016-03 дугаар сарын 15-наас 04 дүгээр сарын 15-ны өдөр	Аймгийн Засаг даргын 2016 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/72 дугаар	1004000 төгрөг аймгийн Засаг даргын бэлтгэл хөрөнгө	

		захирамж		
3	2014-2016 оны үйл ажиллагааны “Бидний –Алтай” хөтөлбөрийн хэрэгжилт, орон нутагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалт, зарцуулсан хөрөнгийг талаарх мэдээллийг сэтгүүл болгон иргэд олон нийтэд хүргэх ажилд	Аймгийн Засаг даргын 2016 оны 04 дүгээр с арын 06-ны өдрийн А/111 дүгээр захирамж	19,0 сая төгрөг аймгийн Засаг даргын бэлтгэл хөрөнгө	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааныхаа мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг тус сэтгүүлээр тайлагнаж ажиллалаа.
4	Жил бүр зохион байгуулагддаг “Санхүүгийн ажилтны нэгдсэн семинар зөвлөгөөн”	Аймгийн Засаг даргын 2016 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/267 дугаар захирамж	1170500 төгрөг аймгийн Засаг даргын бэлтгэл хөрөнгө	
5	“Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн форум” зохион байгуулагдах хөрөнгө	Аймгийн Засаг даргын 2016 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/223 дугаар захирамж	804500 төгрөг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргав.	
Дүн		76000000		

Хоёр. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагаа

2.1. Төрийн албан хаагчдад хууль тогтоомж, шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаар сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах чиглэлээр:

Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, Дотоод ажил шийдвэрийн биелэлт хариуцсан албан хаагч нарт 2016 оны 02 дугаар 25-ны өдөр нэгдсэн сургалт семинарын үеэр Хууль зүйн хэлтсээс сумдын Засаг даргын Тамгын газраас 2015 оны эрх зүйн ажлын болон иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, холбогдох эрх зүйн актын хэрэгжилт, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах талаар сургалт хийж, цаашид анхаарах асуудлаар үүрэг чиглэл өгч мэдээлэл хийлээ.

Аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн албан бичгийн дагуу 2016 оны 04 дүгээр сарын 28-ны 09.00 цагт Хууль зүйн хэлтсээс Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудын талаар сургалт, мэдээллийг зохион байгууллаа.

Алтай –Улиастай ТӨХК-ий ирүүлсэн албан бичгийн дагуу 2016 оны 04 дүгээр сарын 08-ны 09.00 цагт Хууль зүйн хэлтсээс УИХ-аас шинээр батлагдсан хууль тогтоомж, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах сарын аяны хүрээнд хийх сургалт, тус аймгийн Гэмт хэргийн нөхцөл байдал, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудын талаар сургалт, мэдээллийг зохион байгууллаа.

Уг сургалтанд 45 ажилтан албан хаагчид хамрагдлаа.

УИХ-ын 2015 оны намрын чуулганаар хэлэлцэн баталсан Захиргааны ерөнхий хууль 2016 оны 07 сарын 01-ний өдрөөс хэрэгжихтэй холбогдуулан Хууль зүйн яамнаас ирүүлсэн удирдамж чиглэлийн Захиргааны ерөнхий хуулийн сургалтыг Хууль зүйн яам,

Ханнс зайделийн сангийн Эрх зүйн боловсролын академитай хамтран 2016 оны 04 сарын 19-ний өдөр зохион байгууллаа.

Захиргааны ерөнхий хуулийн сургалтад 18 сумын Засаг даргын Тамгын газрын дарга, ЗДТГ-ын Дотоод ажил, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн 36 алба хаагч, 31 төрийн байгууллагын 88 албан хаагч нийт 142 төрийн албан хаагч хамрагдлаа.

Сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу Хууль зүйн яамнаас бэлтгэгдсэн сургагч багш нар явуулж, Захиргааны ерөнхий хуулийн сургалтын гарын авлага Захиргааны ерөнхий хууль 60 ш, Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн сургалтын гарын авлага 60 ш-ийг оролцсон байгууллага, сумдад хуваарилан өглөө.

Мөн сургалтын төгсгөлд Сонгуулийн тухай хууль, Хот суурин газрын дахин хөгжүүлэх тухай хуулиудаар мэдээлэл өгч сургалтад оролцогчидтой санал солилцлоо.

/Эх сурвалж: Тайланд холбогдох бичиг баримт сургалтанд оролцогчдын бүртгэл, тоотыг хавсаргав./

Монгол Улсын Засгийн газраас 2016 оныг Хэрэглэгчийн эрхийг хамгаалах жил болгон зарласантай холбогдуулан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах сарын аяныг 2016 оны 03 дугаар сарын 15-наас 04 дүгээр сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулахаар аймгийн Засаг даргын 2016 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/72 дугаар захирамжаар ажлын хэсгийн бүрэлдэхүүн, шаардагдах хөрөнгийг батлуулж, аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Төгрөг, Бугат, Алтай, Тонхил, Дарив сумдад Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн дарга Ц.Батбаяраар ахлуулсан ажлын хэсэг, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Баттайван, мэргэжилтэн П.Бат-Очир, Татварын хэлтсийн Төрийн захиргаа, хууль эрх зүйн тасгийн дарга Г.Гансүх, Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч Ч.СумъяаИчинхорлоо, Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн 4 улсын шалгагч дээрх сумдад 2016 оны 04 дүгээр сарын 11-17 өдрүүдэд ажиллалаа.

Удирдамжийн дагуу сумдад ажиллахдаа дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Үйлдвэрлэл худалдаа эрхлэгч, иргэд хэрэглэгч нарт зориулсан хууль эрх зүйн сургалт, УИХ-ын 2015 оны хаврын болон намрын чуулганаар хэлэлцэн баталсан хууль тогтоомжийн талаар, сумдад хуулийн хэрэгжилтийг шалгах, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгт зориулсан сурталчилгааны гарын авлага, материал тарааж, ажилласан сумдад Хэрэглэгчийн эрхийг хамгаалах салбар зөвлөлүүдийг 15-с доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудаар мэдээлэл сургалтыг зохион байгуулж, Татварын хэлтсээс 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж буй Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг сумдад шалгаж, хуулийн талаар хэрэглэгч нарт сургалт мэдээллийг өглөө.

Энэхүү “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах аяны ” хүрээнд 5 сумын 800 гаруй иргэд, 100 орчим төрийн албан хаагч хамрагдлаа.

/Эх сурвалж: Тайланд холбогдох бичиг баримт, хавсаргав./

Авлигын эсрэг олон улсын өдөр, Хүний эрхийн өдөр болох 2015 оны 12 дугаар сарын 11-ны өдрийг тохиолдуулан иргэд олон нийтэд Үндсэн хуулиар бататгасан хүний эрхийн үзэл санаа, шударга ёс хүний эрхтэй салшгүй холбоотой болох талаар “Хүний эрх ба хууль тогтоомжийн хэрэгжилт” эссэ нийтлэлийн уралдаан мөн авлигын эсрэг ойлголт сэтгэл зүйг бий болгох зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Авлигын үйлдэл хүний эрхийг зөрчих хэрэгсэл болох нь” сэдэвт гар зургийн уралдаан тэмцээнүүдийг Аймгийн ИТХ-ын ажлын алба, Аймгийн ЗДТГазар, Хүний

эрхийн үндэсний комиссын аймаг дахь ажилтан, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, аймгийн Сэтгүүлчдийн холбоо, Дэлхийн зөн Олон улсын байгууллагатай хамтран зохион байгууллаа.

1. Эссэ нийтлэл, Гар зургийн уралдаан нь нийт шагналын сан 486,0 мянган төгрөг, үүнээс аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар 145,0 мянган төгрөг батлуулж, 84,0 мянган төгрөгийг Дэлхийн зөн Олон Улсын байгууллага, Аймгийн ИТХ-ын ажлын алба 300,0 мянган төгрөгийг санхүүжүүлж, нийт гар зургийн уралдаанд 73 бүтээл ирснээс эхний 3-н байр, тусгай байрт 5 бүтээлийг, Хүний эрх ба хууль тогтоожмийн хэрэгжилт сэдэвт эссэ нийтлэлийн уралдаанд 46 эссэ нийтлэл ирснээс эхний 3-н байр тусгай байрт 3 эссэ нийтлэлийг тусгай бүрэлдэхүүнтэйгээр шалгарууллаа.

Уг шалгаруулалтын бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар шалгаруулалтын ажлын хэсгийн бүрдэлдэхүүнийг баталлаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн ИТХ-ын ажлын алба, Хууль зүйн хэлтэс, Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь ажилтан, Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн зургийн багш, Дэлхийн зөн олон улсын байгууллагын ажилтан нарын бүрэлдэхүүнтэйгээр шалгаруулалтын ажлыг зохион явууллаа.



Зураг №1 Гар зургийн уралдаан шалгаруулах ажлын хэсэг зургийг шалгаруулж байгаа нь.

“Авлигын үйлдэл хүний эрхийг зөрчих хэрэгсэл болох нь” сэдэвт гар зургийн уралдаанд Хантайшир сургуулийн 10 а ангийн сурагч Б.Лүмсүрэн 1 дүгээр байрт, 2 дугаар байрт 1 дүгээр сургуулийн 12 ё ангийн сурагч Н.Шаарийбуу, 3 дугаар байрт Баян-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 11 б ангийн сурагч Г.Нямлхагва шалгарч дурсамж мөнгөн шагнал, тусгай байрт, 1-р сургуулийн 6 д ангийн сурагч Б.Дөлгөөн, 1 дүгээр сургуулийн 6 б ангийн сурагч Б.Нямцогт, 1 дүгээр сургуулийн 8 б ангийн сурагч Б.Хишигбаяр, 2 дугаар сургуулийн 11 в ангийн сурагч Э.Оюун-Эрдэнэ, 3 дугаар сургуулийн 12 в ангийн сурагч Т.Буяндэлгэр нар шалгарч дурсамж, Дэлхийн зөн



Олон улсын байгууллагын гарын бэлгээр тус тус шагнагдлаа.

Зураг №2 1 дүгээр байрт
Хантайшир сургуулийн
10 а ангийн сурагч Б.Лүмсүрэн

Зураг №3 2 дугаар байрт
1 дүгээр сургуулийн 12 ё
ангийн сурагч Н.Шаарийбуу

/Эх сурвалж: баталсан Удирдамж, аймгийн ЗДТГ-ын даргын тушаал, санхүүгийн холбогдох материал зэргийг тайланд хавсаргав. /

Гурав. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа.

Төрийн албан хаагчдад хууль тогтоомж, шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаар сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах чиглэлээр

Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирээдлээс ангид, ил тод, нээлттэй байлгах, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулж байна. Үүнд: Миний нутаг, Алтай радиогоор буюу орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон иргэдтэй уулзах нээлттэй өдөрлөг, аян, хэлэлцүүлэг, төрийн үйлчилгээний нэгдсэн төв зэрэг олон хэлбэрээр хүргэж байна.

1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах талаар:

Аймгийн цахим хуудасны Ил тод байдал-Авлигатай тэмцэх төлөвлөгөө хэсэгт Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад мэдээллийг тавьж, Авлигын эсрэг хууль тогтоомжийн гарын авлагыг аяны хүрээнд иргэдэд тараах зэргээр боломжит хэлбэрээр сурталчилан ажиллалаа.

Тус онд хэрэглэгчийн эрхийг хамгаалах сарын аяны хүрээнд ажилласан сумдад Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар 4 төрлийн плакат, Дэлхийн улс орнуудын Авлигатай тэмцэх ажиллагаа гэсэн туршлага, сургамж ном, Өндөр түвшний авлигаас ангижрах замын зураг гарчигтай Vip эксперт сэтгүүл, хэрэглэгчийн эрхтэй холбоотой бэлтгэсэн гарын авлагуудыг Хууль зүйн хэлтсийн даргын 2016 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 5/502 дугаар албан бичгээр хүргүүлж, гарын авлага материалуудыг цаашид үйл ажиллагаандаа ашиглан иргэд олон нийтэд олшруулж тараах, мэдээллийн самбар болон боломжит арга хэлбэрээр сурталчилж ажиллахыг үүрэг болголоо.

/Эх сурвалж: www.govi-altai.gov.mn -ил тод байдал-Авлигатай тэмцэх төлөвлөгөө хэсэгт байршуулж ажиллаж байгаа бөгөөд энэ хэсгээс үзэх. Тайланд гарын авлага тараасан Хууль зүйн хэлтсийн даргын 2016 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 5/502 дугаар албан бичгийг хавсаргав. /

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн “Авлигын индекс болон авлигад өртөх эрсдэлийн судалгаа” /аймаг нийслэлээр, “Буруу урсгал” баримтат нийтлэл өгөхгүй, бай авахгүй бай, нэхвэл илчил, Монгол Улсын Их Хурлын сонгууль, аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын сонгууль 06 дугаар сарын 29-ний өдөр явагдахтай холбогдуулан Авлигатай тэмцэх газраас бэлтгэж ирүүлсэн Сонгуульд нэр дэвшигч дараахь этгээдээс хандив хүлээн авахыг хориглодог, Сонгуульд нэр дэвшигчид хандив өгөх гэж байгаа бол үүнийг анхаараарай, сонгуулийн хандивын талаарх ойлголт, Сонгуулийн зардал, хандивын хэмжээг олон нийтэд ил тод мэдээлэл хэрэгтэй г.м сурталчилгааны шторкыг Алтай хотын төв талбай болох Жанчивын талбай дээр байрлуулсан LED дэлгэцээр иргэд олон нийтэд таниулах ажлыг зохион байгууллаа.

2.Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох ажлын талаар:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Аймгийн Засаг даргын Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлаг хамтран иргэний оролцоо төслийн хүрээнд тус аймагт 2016 оны 05 дугаар сард Иргэний улс төрийн эрхийн тухай хуулийн төслийн танилцуулгаар хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Тус хэлэлцүүлэгт 150 гаруй иргэд, төрийн албан хаагч нар оролцож, бэлтгэж тараасан хуудсаар саналаа өглөө.

Төрөөс залуучуудын талаар баримталж буй бодлого "Монгол залуу хүн" үндэсний хөтөлбөрт уялдуулан аймгийн хэмжээнд орон нутгийн залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх түүнд тусгах санал авах хэлэлцүүлгийг 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр аймгийн иргэний танхимд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт төрийн болон ТББ, хувийн хэвшлийн 40 гаруй залуучууд оролцож санал бодол дуу хоолойгоо хүргэлээ. Хэлэлцүүлэгт:

1. Оюунлаг залуу хүн -Алтайн баялаг
2. Хөдөлмөрч залуу хүн-Алтайн баялаг
3. Эрүүл залуу хүн-Алтайн баялаг
4. Зөв залуу хүн-Алтайн баялаг

Сэдвийн хүрээнд салбар хэлэлцүүлэг зохион байгуулж хөтөлбөрт тусгах саналуудаа гарган ажиллалаа.

[/govi-altai.khural.mn](http://govi-altai.khural.mn)-цахим хуудасны-үзэл бодол цэсний иргэний танхим хэсгээс үзнэ үү. Зар тараасан байдал, болон хуралдааны тэмдэглэлийг тайланд хавсаргав./

Монгол Улсад Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиуд шинээр хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргын “Сургалт зохион байгуулах тухай” 2016 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 1-4/788 тоот албан бичгийн дагуу Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүнээр ажиллах болон сургуулиудын нийгмийн ажилтан 20 албан тушаалтныг чадваржуулах сургалтыг сургагч багш болох Хүүхэд, гэр бүл судлаач Х.Баавгай Ph.D тус аймагт 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдөр зохион байгууллаа.

Тус чадваржуулах сургалтанд Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс, Прокурорын газар, Цагдаагийн газар, анхан шатны шүүхийн шүүгч, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Шүүхийн шинжилгээний алба, Эрүүл мэндийн газар, Хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь ажилтан, Эрх зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч, сургуулиудын нийгмийн ажилтнууд хамрагдлаа.

Сургалтаар шинээр мөрдөгдөж байгаа Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудын онцлог зохицуулалт, байцаан шийтгэх ажиллагааны үед гэмт хэрэг үйлдсэн болон гэрч хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаар харилцан мэдээлэл солилцож Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны журмын төсөлд холбогдох байгууллагуудаас санал өглөө.

Аймгийн Засаг даргын зүгээс хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэр гараагүй .

Тус аймгийн Засаг даргын "Захирамж хүчингүй болгох тухай" 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/160 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын 2005 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 82 дугаар захирамжийг хүчингүй болгож, Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам"-ын дагуу хянуулж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр Хууль зүйн яамны Хууль зүйн нэгдсэн бодлогын газарт хүргүүлж, Хууль зүйн яамны 2016 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 1-3/1874 дугаар Төрийн нарийн бичгийн даргын албан тоотгоор захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн бүртгэлд хөдөлгөөн хийсэн талаар мэдэгдсэний дагуу бүртгэл хөдөлгөөнийг хийлээ.

/Эх сурвалж: аймгийн Засаг даргын Захирамжийг тайланд хавсаргав. /

3.Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар:

2016 оны 3 дугаар улирлын байдлаар аймгийн Засаг даргын 357 захирамж, 2 албан даалгавар гарснаас 48 нь ажлын хэсэг байгуулах, комисс томилох тухай захирамж байна. Үүнээс хяналт, шалгалттай холбоотой 10 захирамж гарсан бөгөөд тус шийдвэрийн дагуу хийж, хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг танилцуулж ажиллалаа.

/Эх сурвалж: www.govi-altai.gov.mn- ил тод байдал-хяналт шалгалт хэсгээс үзнэ үү. Хяналт шалгалтын зорилго, агуулга, авсан арга хэмжээний талаарх мэдээллийг хавсаргав /

Аймгийн Санхүү хяналт аудитын алба нь 2016 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Засаг даргатай байгуулсан "Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ"-нд тусгасаны дагуу аймгийн төвийн болон сумдын 84 байгууллага, тусгай зориулалтын сангийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийхээр төлөвлөснөөс өнөөдрийн байдлаар 41 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгууллаа.

Төлөвлөгөөт бусаар Төгрөг сумын ЗДТГ-ын 2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд , сум дундын эмнэлэгийн 2012-2016 оны баримтад, сум хөгжүүлэх сан болон орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд , Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн хүсэлтийн дагуу Хөхморьт , Баян-Уул сумдын төсөвт байгууллагууд, сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг тус тус хийлээ.

Тайлант хугацааны 3 дугаар улирлын байдлаар хяналт шалгалтаар нийт 1585961,1 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 111994,2 мянган төлбөрийн акт тогтоож , 46601,9 мянган төгрөгийн дүн бүхий 10 албан шаардлага хүргүүлж, хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах цаашид давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, шалгалтын танилцуулгаар үүрэгжүүлэн биелэлтийг тооцон ажиллалаа.

Хяналт шалгалтанд хамрагдсан байгууллагуудын шалгалтын дүнг тухайн байгууллагын удирдах зөвлөл болон ажилтан албан хаагчдад танилцуулж, аймгийн govi-altai.gov.mn цахим хуудсанд тухай бүр байршуулан иргэд олон нийтэд мэдээлж, санхүүгийн хяналт шалгалтын материалаар цахим сан үүсгэн баяжилт хийлээ.

/Эх сурвалж: Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалыг арилгасан талаар/ Дараах линкээр орж үзнэ үү

4.Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаад, зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх /цахим хуудас/ талаар:

Орон нутгийн төсвийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах бүхий л үе шатанд төсвийн ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор орон нутгийн телевиз, радио, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж хэвшүүлээ. Тэрчлэн “Шилэн дансны тухай” хууль, “Авлигын эсрэг” хууль, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль болон “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу аймгийн цахим хуудас болон шилэн дансны мэдээллийн нэгдсэн системд тавигдах хуульд заасан мэдээллийг цаг тухай бүр нь байршуулсны зэрэгцээ төсвийн ил тод байдлын самбарыг ажиллуулж мэдээ, мэдээллийг тухай бүр нь хуулийн хугацаанд бүрэн байршуулж хэвшүүлсэн. Аймгийн цахим хуудсанд аймгийн ИТХ-аас баталсан 2016 оны орон нутгийн төсөв, түүнд өөрчлөлт хийсэн төсвийн тодотгол, ТЭЗ-ийн 2016 оны сар, улирлын мэдээ, тайлан, ТЭЗ-ийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан /бүрэн эхээр/, түүнд хийсэн аудитын дүгнэлт болон түүнд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, төсвийн хэтрэлт, хэмнэлт зэрэг хуульд заасан мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж ирсэн болно.

Дээрх тайлан, мэдээ, мэдээллүүдийг аймгийн албан ёсны цахим хуудас / www.govi-altai.gov.mn /-ны Шилэн данс цэснээс авах боломжтой.

Аймгийн албан ёсны цахим хуудсанд дараах мэдээллүүдийг байршуулсан. Үүнд:

- ✓ **Тухайн жилийн төсөв:** Аймгийн ИТХ-аас баталсан 2016 оны орон нутгийн төсөв. / <http://govi-altai.gov.mn/upload/files/2cc8c315861697789f7fc1f29ca94aa9.pdf> , <http://govi-altai.gov.mn/upload/files/087256c8b4fcb8bf0a5b84784c4cc4e7.pdf> линкээр орж үзнэ үү./
- ✓ **Өмнөх оны төсвийн гүйцэтгэл:** Орон нутгийн төсвийн Ерөнхийлөн болон Төвлөрүүлэн захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан (бүрэн эхээр). /<http://govi-altai.gov.mn/upload/files/06ed76e4ad522a8182cbaa4cdec7f9a9.pdf> линкээр орж үзнэ үү./
- ✓ **Сарын төсвийн гүйцэтгэл:** Төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээг дараа сарын 08-ны дотор аймгийн цахим хуудсанд тогтмол байршуулж хэвшсэн. / <http://govi-altai.gov.mn/34/all> линкээр орж үзнэ үү./
- ✓ **Хагас жилийн төсвийн гүйцэтгэл:** Орон нутгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг ТЭЗ-н хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаас харна уу. /<http://govi-altai.gov.mn/upload/files/6b9d833046799d786a90c59f87e57d2e.pdf> линкээр орж үзнэ үү./
- ✓ **Хагас жилийн санхүүгийн тайлан:** Орон нутгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан (бүрэн эхээр). /<http://govi-altai.gov.mn/upload/files/6b9d833046799d786a90c59f87e57d2e.pdf> линкээр орж үзнэ үү./
- ✓ **Дараа жилийн төсвийн төсөл:** 2017 оны төсвийн Ерөнхийлөн захирагчийн Сангийн яамаар хянагдсан төсвийн төсөл. / <http://govi-altai.gov.mn/upload/files/24bab2cdc11318485300d13cd0187a33.pdf> линкээр орж үзнэ үү./
- ✓ **Жилийн эцсийн санхүүгийн тайлан:** Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2015 оны жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангууд. / <http://govi-altai.gov.mn/34/item/796> линкээр орж үзнэ үү./
- ✓ **Санхүүгийн тайланд өгсөн аудитын дүгнэлт:** Орон нутгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлт.

- / <http://govi-altai.gov.mn/upload/files/f5bbfd087db652458c1b39507fd9bcb5.pdf> линкээр орж үзнэ үү. /
- ✓ **Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:** Орон нутгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, түүний биелэлт, тайлан. / <http://www.govi-altai.gov.mn/upload/files/9bab6aca5082a5d0a3a4bd4e63001f66.pdf> линкээр орж үзнэ үү./
 - ✓ **Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар:** Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны эхний хагас жил болон 3 дугаар улиралын байдлаарх төсвийн хэтрэлт, хэмнэлт. (Дэлгэрэнгүйгээр) /<http://govi-altai.gov.mn/upload/files/6510e72f68c88b48f7931ed5867437b6.pdf> линкээр орж үзнэ үү./
 - ✓ **Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:** Аймгийн ИТХ-аас баталсан төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсвийн тодотгол (бүрэн эхээр) / <http://govi-altai.gov.mn/upload/files/50b2cc35d61f1b8dc70af6ba5c3929e9.pdf> линкээр орж үзнэ үү./
 - ✓ **Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /матварын орлого, матварын бус орлогын талаарх мэдээлэл:** Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, түүний гүйцэтгэлийн сарын мэдээг (дүн, хувиар) сар бүрийн 08-ны дотор тогтмол байршуулж хэвшсэн. / <http://govi-altai.gov.mn/34/all> линкээр орж үзнэ үү./
 - ✓ **Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг цахим хуудсанд дэлгэрэнгүйгээр байршуулсан:** / <http://govi-altai.gov.mn/upload/files/8f0df36168f96cb3b43999aeba8bbfb1.pdf> линкээр орж үзнэ үү./
 - ✓ **Концессийн талаарх мэдээлэл:** Аймгийн цахим хуудасны **ил тод байдал** цэсний **концесс** дэд цэсний **урилга шийдвэр, хэрэгжилт, жагсаалт** салбар цэснээс дэлгэрэнгүй мэдээлэлийг авах боломжтой.
 - ✓ **Байгууллагын батлагдсан орон тоо.** Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг Шилэн дансны нэгдсэн системд байгууллага тус бүр оруулж байгаа учир аймгийн цахим хуудсанд байршуулаагүй болно. Жишээ нь: Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоонд орсон өөрчлөлтийг <https://www.shilendans.gov.mn/org/2163?form=1024479&year=2016&group=2&task=1617> линкээр орж үзэх боломжтой.

Бусад мэдээллийн талаар:

- ✓ **Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт байхгүй болно.**
- ✓ **Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр Шилэн дансны нэгдсэн системд байгууллага тус бүр оруулж байгаа учир аймгийн цахим хуудсанд байршуулаагүй болно.** Жишээ нь: Аймгийн Засаг даргын Тамгын газрын шилэн дансны 5 сая төгрөгөөс дээш гүйлгээг <https://www.shilendans.gov.mn/org/2163?form=1024182&year=2016&group=0&task=1617> линкээр орж үзэх боломжтой... гэх мэт.
- ✓ **Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хийгдсэн концессийн дэлгэрэнгүй мэдээллийг аймгийн цахим хуудасны **ил тод байдал** цэсний **концесс** дэд цэсний **урилга шийдвэр, хэрэгжилт, жагсаалт** салбар цэснээс дэлгэрэнгүй мэдээлэлийг авах боломжтой бөгөөд бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр гараагүй болно.**
- ✓ **Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөр.** Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн “Хот байгуулалтын салбарын МОН-2301 төсөл”-ийн хүрээнд Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын

гадна дулаан, ус хангамж, ариутгах татуургын сүлжээг шинэчлэх 4,6 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл хэрэгжиж 2015 онд хүлээлгэн өгсөн.

5.Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл бүртгэлийн үйл ажиллагааг ил тод , нээлттэй байлгах , олон нийтэд танилцах боломжоор хангах талаар:

Аймгийн засаг дарга болон байгууллагаас хэдэн төрлийн тусгай зөвшөөрөл олгодог талаарх нэр хаяг холбогдох эрх зүйн үндэслэл, тусгай зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх, материалын нэрс, жагсаалт, шийдвэрлэх хугацаа зэрэг мэдээллийг агуулсан жагсаалтыг гаргаж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсээс гаргаж, цахим хуудсанд байршууллаа.

/Эх сурвалж: www.govi-altai.gov.mn -ил тод байдал-тусгай зөвшөөрөл хэсгээс үзнэ үү. /

Аймгийн засаг даргаас олгож буй Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг байгуулах, архи согтууруулах ундаа, худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, Эрүүл мэндийн чиглэлээр олгож буй тусгай зөвшөөрөл эзэмшигч, хуулийн этгээд, олгосон болон дуусах хугацааг харуулсан дэлгэрэнгүй судалгааг цахим хуудсанд байршуулж, иргэд олон нийт танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллалаа.

/Эх сурвалж: www.govi-altai.gov.mn -ил тод байдал-үйл ажиллагаа-тусгай зөвшөөрөл-мэдээний төрлүүд сургалтын тусгай зөвшөөрөл, согтууруулах ундаа, Эрчим хүч- эрүүл мэнд гэсэн хэсгүүд дээр дарж үзнэ үү. /

6.Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах талаар:

Тус 2016 онд төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтыг холбогдох, журам, зааврын дагуу 1 удаа зохион байгуулж, сонгон шалгаруулалт явуулсан тухай бүр болон төрийн жинхэнэ албан тушаалд нэр дэвшсэн иргэдийн холбогдох мэдээллийг www.govi-altai.gov.mn сайтаар тогтмол мэдээлж ажиллалаа.

Төрийн албаны мэргэшлийн шалгалтад 40 ажлын байр зарлагдсанаас 1 ажлын байранд бүтцийн өөрчлөлт орсны улмаас иргэдийг бүртгээгүй, 10 ажлын байранд иргэн бүртгүүлээгүй бөгөөд 27 ажлын байранд 149 иргэн бүртгүүлэн өрсөлдсөнөөс 11 ажлын байранд шалгалт өгсөн иргэд тэнцээгүй, 18 ажлын байранд 60 ба түүнээс дээш оноотой 49 иргэн тэнцсэн байна.

Сул орон тооны зарыг Төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn, аймгийн www.govi-altai.gov.mn цахим хаяг, аймгийн Засаг даргын Тамгын газрын зарын самбар болон салбар зөвлөлийн мэдээллийн самбаруудад 21 хоногийн өмнө байршуулж хэвшилээ.

/Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн албан бичиг холбогдох баримт материалыг тайланд хавсаргав./

Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажил үүргийн хуваарийг тодорхой болгож, аймгийн цахим хуудсанд бүтэц чиг үүрэг, ажилтнуудын хариуцан ажиллах чиглэл, емейл хаяг, өрөөний ажлын утасны дугааруудыг байршууллаа.

/Эх сурвалж: www.govi-altai.gov.mn -нутгийн удирдлага-Аймгийн ЗДТГазар цэснээс үзнэ үү. /

7.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах , түүнтэй танилцах боломжоор хангах талаар:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий төлөвлөгөөг www.meps.gov.mn, www.e_procurement.mof.gov.mn, www.govi-altai.gov.mn сайтуудад байршуулж, тухайн бараа, ажил үйлчилгээ авах тендерийн баримт бичгийг хяналтын зураг төсөв ашиглан боловсруулдаг болон батлагдсан төсвөөс хамаарч тендерийн журмыг сонгон, урилгыг цахим хуудсууд болон албаны мэдээллийн самбар, “Зууны мэдээ” сонинд тавьж иргэд олон нийтэд түгээн ажиллалаа.

/Эх сурвалж: Сонины хуулбарыг хавсаргаав/

2016 онд зарлагдсан тендерүүдэд оролцсон компаниудад тендерийн баримт бичигт тусгагдсан заалтууд болон хууль тогтоомжид нийцсэн болон нийцээгүй талаарх үндэслэлийг мэдэгдэл хэлбэрээр албан бичгээр хүргүүлж, шалгарсан болон шалгараагүй оролцогчдын мэдээлэл, шалтгаан нөхцлийг тухай бүр шилэн дасны портал системд байршуулснаар олон нийтэд танилцах боломж нээгдлээ.

Тус алба нь 2016 онд зарлагдах бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг 100% цахим хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөн ажиллалаа.

/Эх сурвалж: Шилэн дасны нэгдсэн портал системтэй аймгийн цахим сайтын шилэн данс-цэсний-тендер хэсэгтэй холбосон/

Аймгийн Худалдан авах ажиллагааны алба нь 2016 он гарсаар нийт 48 төсөл арга хэмжээг төлөвлөгөөндөө тусган төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж гүйцэтгээчийг сонгон шалгаруулан ажиллаж байна.

Он гарсаар Улсын төсвийн 749,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх 3 ажил, 1113,0 сая төгрөгийн 4 бараа нийлүүлэх, Орон нутгийн төсвийн 194,5 сая төгрөгийн хөрөнгөөр санхүүжигдэх 6 ажил, Орон нутгийн хөгжлийн сангийн 1,298,5 сая төгрөгийн хөрөнгөөр санхүүжигдэх 25 ажил, 136,6 сая төгрөгийн 3 барааны тендер, 175,0 сая төгрөгийн 4 зөвлөх үйлчилгээний, Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний 67,0 сая төгрөгийн зардалтай 2 ажил, Орон нутгийн замын сангийн 257,4 сая төгрөгийн 1 ажлын тендерүүдийг тус тус зохион байгуулаад байна. Нийт 48 бараа, ажил үйлчилгээнд 3,991,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тусгагдсан байна.

Нийт 44 үнэлгээний хороог аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж, давхардсан тоогоор 226 гишүүд ажилласан ба үүнээс иргэний төлөөлөл 44, төрийн бус байгууллагын төлөөлөл 44 хүнийг оролцуулаад байна.

/Эх сурвалж: Тайланд үнэлгээний хороодыг байгуулсан Засаг даргын захирамжийг хавсаргаав/

8.Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох талаар :

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтыг хэрэгжүүлж, Төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг хэлтэс бүрээр шинэчлэн боловсруулж, хийх ажил үүргийн хуваарийг тодорхой болгож, аймгийн цахим хуудсанд бүтэц чиг үүрэг, ажилтнуудын хариуцан ажиллах чиглэл, емейл хаяг, өрөөний ажлын утасны дугааруудыг байршууллаа.

/Эх сурвалж: www.govi-altai.gov.mn -Нутгийн удирдлага-аймгийн ЗДТГазар цэснээс үзнэ үү. /

9.Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах талаар:

Төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн ажил гүйцэтгэх саналуудыг дэмжин төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэхээр ажиллаж байна.

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газар нь аймгийн Засаг дарга, ЗДТГ-аас иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн талаарх “Хэрэглэгчийн үнэлгээ” хийлгэх ажлыг сонгон шалгаруулах зарыг 2015 оны 09 дүгээр сарын 28-нд аймгийн цахим хуудсанд байршуулж, сонинд урилгыг тавьж олон нийтэд танилцуулан гүйцэтгэгчийн сонгон шалгарлуултыг нээлттэйгээр зарлаж, Монгол эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих сан ТББ-ын аймаг дахь салбар гүйцэтгэгчээр шалгарч Аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газраас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар , хүртээмжийн талаар иргэдээс санал асуулга авч хэрэглэгчийн үнэлгээг хийж, тайлангаа 2016 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр аймгийн Засаг даргын Тамгын 2015 оны А/39 дүгээр тушаалаар томилогдсон ажлын хэсэгт танилцуулж, ажлын хэсэг аймгийн удирдлагуудад танилцуулан цаашид авах арга хэмжээг төлөвлөн иргэдэд мэдээлэл авах боломжийг хялбар, хурдан авах боломжийг бүрдүүлж аймгийн вэб сайтыг шинэчлэн сайжруулах ажлыг зохион байгууллаа.

Тухайн жилд хамтран ажилласан ТББ-ын жагсаалт

№	ТББ-ын нэр тэргүүний нэр	Шийдвэрийн дугаар огноо	Санхүүжилэх мөнгөн дүн төгрөг
1	Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих сан ТББ-ын аймаг дахь салбарын тэргүүлэгч Д.Оюундарь	Аймгийн Засаг даргын 2015 оны А/368 дугаар захирамжаар	1500000 төгрөгийг орон нутгийн төсвийн төрийн өмнөөс гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлаас Хэрэглэгчийн үнэлгээ хийсэн тайланг хүлээн авч 2016 оны 06 дугаар сарын 03-нд 450 000 мянган төгрөгийг санхүүжилтийг өглөө.
2	Аймгийн Тогооч нарын холбооны тэргүүн Я.Сувдмаатай	Аймгийн Засаг даргын 2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/146 дугаар захирамжаар	1400000 төгрөгийг орон нутгийн төсвийн төрийн өмнөөс гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлаас
3	Эко-Алтай төслийн багийнханд	Аймгийн Засаг даргын 2016-08-30-ны өдрийн А/317 дугаар захирамжаар	2000000 төгрөгийг орон нутгийн төсвийн төрийн өмнөөс гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлаас
Дүн			7900000

/Хэрэглэгчийн үнэлгээ хийх ТББ-ыг сонгон шалгаруулсан, шалгарсан ТББ-ын хийсэн ажлын тайлан, ТББ-уудаар төрийн өмнөөс гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын гэрээ, санхүүжүүлсэн аймгийн Засаг даргын шийдвэр зэрэг холбогдох бичиг баримтыг тайланд хавсаргаав./

10.Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх талаар:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын ЭБАТ-ыг Засаг даргын Тамгын газрын тушаалаар томилж, ажлын байрны тодорхойлолтод тусгаж, холбогдох журмын дагуу албан тушаалын цалингийн 30 хувиар нэмэгдлийг олгож ажилж байна.

/Ажлын байрны тодорхойлолт, нэмэгдэл олгох шийдвэрийг тайланд хавсаргаав./

Албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын 2015 оны мэдүүлэг түүнд орсон их хэмжээний өөрчлөлтийг хуулийн хугацаанд бүртгэж, мэдээ тайлан, ЭБАТ-ын бүртгэлийг холбогдох журмын дагуу бүртгэж, тайланг Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд хүргүүлж ажиллалаа.

Тайлангийн хугацаанд ХАСХОМ-ээ шинэчлэн гаргасан 247, 2016 онд мэдүүлэгт их хэмжээний өөрчлөлт орсон 3, 2016 онд шинээр томилогдсон 26 албан тушаалтны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд хүлээн авч хянан баталгаажууллаа.

Тус 2016 онд ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн 259 мэдэгдэл, Хувийн ашиг сонирхлын 29 урьдчилсан мэдүүлгийг хүлээн авч, Авлигатай тэмцэх газарт хянуулж, бүртгэлийг цаасаар болон цахимаар бүртгэлээ.

Сумдын ЭБАТ-уудыг мэргэжил арга зүйгээр хангах зорилгоор Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, албан тушаалтны мэдүүлгийг бүртгэх, хянах хадгалах эрх бүхий албан тушаалтны болон мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарт хуулийн хэрэгжилтийг хангуулах, тайлан мэдээг заасан хугацаанд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2016 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 3/35 тоот албан бичгээр санууллаа.

/Албан бичгийг тайланд хавсаргав./

11.Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх талаар:

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 6.1.9-д заасны дагуу байгууллагын ажилтан албан хаагчид нэг бүрээр мөрдүүлэх ёс зүйн дүрмийг боловсруулан Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст аймгийн Засаг даргын Тамгын газрын 2015 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн 3/572 дугаар албан бичгээр уг төсөлд санал авахаар хүргүүлж ажиллаж, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2015 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн А/20 дугаар тушаалаар “Аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагчдын ёс зүйн дүрэм”-ийг батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

/Санал авахаар хүргүүлсэн албан бичиг, батлагдсан ёс зүйн дүрмийг хавсаргав. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дүрмийг Эх сурвалж: www.govi-altai.gov.mn- Ил тод байдал - Хүний нөөцийн ил тод байдал – Төрийн албаны салбар зөвлөл-сонгон шалгаруулалт – ТАХ-ын Ёс зүйн дүрмийг үзэх/

Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ёс зүйн дүрмийг албан хаагч нэг бүрт танилцуулан гарын үсгээр баталгаажуулж ажиллалаа.

Тус онд шинээр томилогдсон албан хаагч нарт байгууллагын ёс зүйн дүрмийг танилцууллаа.

/ Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ёс зүйн дүрэмтэй танилцсан бүртгэлийг тайланд хавсаргав./

2016 оны хагас жилийн байдлаар аймгийн төрийн байгууллагуудын ёс зүйн хорооноос төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийг гаргасан 9 албан хаагчид байгууллагын удирдлагын шийдвэрээр Төрийн албаны хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Төрийн жинхэнэ албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн талаарх мэдээллийг аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл болон “Иргэн таныг сонсож байна-70481111” утас, Аймгийн ЗДТГ-ын үүдний санал хүсэлтийн хайрцагаар тогтмол хүлээн авч ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу Хууль зүйн хэлтсийн даргын 2016 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 5/70 дугаар албан бичгээр зөрчил үүссэн, үүсч болзошгүй байдал үүссэн тохиолдолд ашиг сонирхлын зөрчилгүй гэсэн мэдэгдэл тайлбарыг гаргаж ажиллахыг зөвлөлөө.

/Зөвлөмжийг тайланд хавсаргав/

Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс 2016 оны 02 дугаар сард аппарат дээр явуулах ажлын төлөвлөгөөнд байгууллагын ёс зүйн дүрэм, хөдөлмөрийн дотоод журмыг албан хаагчдад таниулах зорилгоор “АХА” тэмцээнийг зохион байгууллаа.



/эх сурвалж: 02 дугаар сард хийх ажлын төлөвлөгөөг тайланд хавсаргав./

12. Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх талаар:

Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалт, давхар ажил эрхлэлтийн ойлголт талаарх мэдээллийг вэб сайтанд байршууллаа.

/ Эх сурвалж: www.govi-altai.gov.mn ил тод байдал-Авлигын эсрэг үйл ажиллагаа – цэс хэсгээс үзнэ үү./

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу тайлант хугацаанд давхар ажил эрхлэх зөвшөөрөл, шийдвэр гаргасан зүйл байхгүй байна.

13. Байгууллагын удирдлагаас гаргаж, буй шийдвэрийн ил тод , нээлттэй байдлыг хангах талаар:

Удирдлагын шийдвэрийг цахим хуудсанд цаг тухай бүрт байрлуулж, иргэд олон нийт танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллалаа.

/ Эх сурвалж: www.govi-altai.gov.mn хууль эрх зүй-цэснээс сонгож харах./

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох аймгийн ИТХ, ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолыг аймгийн ИТХ-ын цахим хуудсанд тухай бүр байршуулж, иргэд олон нийт танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллалаа.

/ Эх сурвалж: www.govi-altai.khural.mn –ил тод байдал-тогтоол шийдвэр цэснээс сонгож харах./

Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, заавар мөн иргэдэд хэрэгцээтэй хууль тогтоомжуудын талаарх танилцуулгыг цахим хуудсандаа байршуулж ажиллалаа.

/эхсурвалж: www.govi-altai.gov.mn –хууль эрх зүй-гарын авлага цэснээс үзнэ үү./

14. Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах талаар:

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагууд хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болох Миний нутаг Телевиз, Алтайн мэдээ сонин, Алтай радиогоор цаг тухай бүр иргэд олон нийтэд мэдээлж үйл ажиллагаагаа сурталчилан ажиллаж байна.

Худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл, аймгийн нийгэм эдийн засгийн байдал, хууль, эрх зүйн талаарх болон цаг үеийн бусад мэдээ мэдээллийг нийтэд мэдээлж сурталчилж ажиллаж байна.

/эх сурвалж: Алтайн мэдээ сонины дугааруудаас тайланд хавсаргав./

Аймгийн ЗДТГ-ын хэмжээнд иргэдийн өргөдөл гомдлыг бичгээр болон утсаар, цахим хэлбэрээр шуурхай хүлээн авах, шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлж, өргөдөл, гомдол хүсэлт мэдээлэл хүлээн авах ажилтаны нэр албан тушаал, иргэдээ сонсох 70481111 утасны харилцах утсыг www.govi-altai.gov.mn-нутгийн удирдлага –аймгийн ЗДТГазар-Хууль зүйн хэлтэс танилцуулга, мөн цахим хуудасны ил тод байдал-санал авах булан хэсэгт дарж аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлтээ info@gobi-altai.gov.mn цахим шуудангаар ирүүлэх боломжтой мэдээллийг байршуулж, ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн байгууллага сумдаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэнд хяналт тавьж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт улирал бүрийн 10-ны дотор тайлагнаж ажиллаж байна.

2016 оны 03 дугаар улирлын байдлаар нийт 8252 өргөдлөөс: Хүсэлт 7642 /92.6 %/, Санал 450 /5.5 %/, Гомдол 160 /1.9 %/ -ийг тус тус эзлэж байна.

Үүнд:

- Газрын харилцааны асуудлаар 2120 /25.7%/
- Иргэний бүртгэл, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой 2008 /24.3%/
- Нийгмийн халамжийн үйлчилгээ авах хүсэлт 1509 /18.3%/
- Ажлын байр хүссэн, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой 508 /6.2%/
- Нийтийн аж ахуйн үйлчилгээний асуудлаар 405 /4.9%/
- Бусад 1702 /20.6%/

Иргэдээ сонсох 70481111 утсаар 234 иргэн ханджээ.

Иргэдийн санал хүсэлт хүлээн авах нээлттэй утсанд болон иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол санал, хүсэлт болон шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг орон нутгийн Алтай радиогоор тогтмол хугацаанд иргэд олон нийт мэдээлж, ажиллалаа.

/Эх сурвалж: Алтай радиогоос мэдээлэл явуулсан тодорхойлолтыг хавсаргав./

15.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр:

Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал үйлчилгээний жагсаалтыг гаргаж, 2015 онд авлигын эрсдлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг оновчтой, үр дүнтэй зохион байгуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах зорилгоор аймагт үйл ажиллагаа явуулж, буй байгууллагуудын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал, Авлигад өртөмтгий байдлыг тодорхойлох, төрийн байгууллагуудын анхааран хэрэгжүүлэх бодлогын чанартай санал зөвлөмжийг боловсруулах зорилтын хүрээнд Аймгийн Засаг даргын Тамгын газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал үйлчилгээний жагсаалт, авлигад өртөх магадлалтай байгууллагын жагсаалтыг иргэдээс санал асуулга авч дүн шинжилгээ хийж, дүнг аймгийн вэб сайтад тавьж, хууль сурталчлах арга хэмжээний үеэр дүнг, иргэд олон нийтэд болон төсөвт байгууллагын албан хаагчдад танилцуулж ажиллалаа.

/ Эх сурвалж: санал асуулгын дүнг www.govi-altai.gov.mn ил тод байдал-авлигын эсрэг хэсгээс харах. /

Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх хүнд суртал, чирэгдлийг арилгах, үйлчилгээний чанар шуурхай байдлыг хангах чиглэлээр:

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах үүргийг нь сануулан Хууль зүйн хэлтсийн даргын 2016 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 5/70 дугаар албан бичгээр албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ талаар эрх бүхий албан байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэж ажиллах зөвлөмжийг төсвийн байгууллагын дарга нарт хүргүүлж, ажилласнаар 2016 оны 11 дүгээр сарын 10-ны байдлаар аймгийн дүнгээр нийт 259 мэдэгдэл тайлбарыг цаасаар хүлээн авч, цахим системд бүртгэж ажиллалаа.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв нь газрын харилцаа, барилга хот байгуулалт, мэргэжлийн хяналт, хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээ, нийгмийн даатгал, татвар, иргэн болон хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр нийт 156 үйлчилгээг үзүүлэн ажиллаж байгаа бөгөөд цаашид бусад төрлийн үйлчилгээнүүдийг нэмж үзүүлэх боломжтой.

Эх сурвалж: www.govi-altai.gov.mn-цаг үеийн мэдээ –үйл явдлын мэдээ хэсгээс үзнэ үү./

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газраас өөрийн үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд мэдээллийг шуурхай, бодитой хүргэх зорилгын хүрээнд аймгийн төвийн албан байгууллагуудын шуурхай зөвлөгөөнийг 7 хоногийн 1 дэх өдөр хийж, цаг үеийн мэдээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийж, мэдээ

мэдээллийг орон нутгийн Миний нутаг ТВ-ээр болон байгууллагын цахим хуудсаар мэдээлж төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг иргэдэд хүргэж ажиллаж байна.

/Эх сурвалж: www.govi-altai.gov.mn- цаг үеийн мэдээ цэсний –шуурхай зөвлөгөөн хэсгээс үзнэ үү./

Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, агентлагийн дарга нарыг чадавхжуулах, шударга ёс, ёс зүйг сайжруулах зорилгоор “Ухаалаг харилцаа-амжилтын эхлэл” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаалыг хавсаргав./

“Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 09 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/23 дугаар тушаалаар “аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтнуудын орон тоо, хэлтсүүдийн чиг үүрэг, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж ажлын ачааллыг тэнцвэржүүлснээр үр дүнгийн гэрээг үнэн зөв шударга үнэлж, дүгнэх боломжтой боллоо.

/Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын тушаал, /

16.Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийн дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх талаар авсан арга хэмжээний талаар:

Авлигатай тэмцэх газраас 2015 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 05/7506 тоот албан бичгээр “Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай” албан бичгийг ирүүлсэний дагуу “Нийтлэг үйлчилгээ” орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын дарга Т.Лодойг аймгийн Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Б/74 дүгээр захирамжаар үүрэгт ажлаас нь чөлөөлж, хууль тогтоомжид заасны дагуу албан тушаалд томилогдохдоор нэр дэвшиж байгаа этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргуулан холбогдох баримтыг бүрдүүлж, хянуулах арга хэмжээг авлаа.

/аймгийн Засаг даргын захирамж, албан бичгийг тайланд хавсаргав./

Аймгийн Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/407 тоот “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжаар “Нийтлэг үйлчилгээ” орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын “Хүнхэр” орон нутгийн өмчит амралтын газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг Санхүүгийн хяналт аудитын албатай хамтран 2015 оны 12 дугаар сарын 09-ний өдрөөс 12 дугаар сарын 11-нийг дуустал ажлын 3 хоногийн хугацаанд хийж, дүнг илтгэх хуудсаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлж ажиллалаа.

/аймгийн Засаг даргын захирамж, хяналт шалгалтын илтгэх хуудсийг тайланд хавсаргав./

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу Хууль зүйн хэлтсийн даргын 2016 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 5/70 дугаар албан бичгээр зөрчил үүссэн, үүсч болзошгүй байдал үүссэн тохиолдолд ашиг сонирхлын зөрчилгүй гэсэн мэдэгдэл тайлбарыг гаргаж ажиллахыг зөвлөлөө.

Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн ажлын төлөвлөгөө болон Авлигын эсрэг 2016 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийт 5 суманд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах аяны хүрээнд ажиллахдаа Хууль зүйн хэлтсийн 2016 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 5/70 дугаар албан тоотоор хүргүүлсэн Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийн хэрэгжилттэй танилцаж цаашид анхаарах санал зөвлөмжийг өгч ажиллалаа.

Авлигатай тэмцэх газраас хариуцлага тооцож арга хэмжээ авахуулахаар албан бичиг ирээгүй.

Дүгнэлт:

Тус аймгийн Засаг даргын Тамгын газраас болон төрийн байгууллагуудаас Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хүлээсэн үүргийн дагуу шаардлагатай төсөв мөнгө төлөвлөж, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг зорихгүйгээр байгууллагын түвшинд авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байгууллагын соёлыг төлөвшүүлэх, түүнд чиглэсэн үйл

ажиллагааг тасралтгүй явуулж, авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангуулах, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэх талаар жил бүр төлөвлөж, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ирлээ.

Аймгийн хэмжээнд 2016 онд авлигын эрсдлийг бууруулах, шударга ёс ил тод байдлыг хангах талаар шинээр санаачилж хийсэн ажлууд:

“Мэдээллийн ил тод байдлыг хангах зарим хэмжээний арга хэмжээний тухай” Аймгийн засаг даргын 2014 оны А/62 дугаар захирамж гарч, мөн жил бүр Авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангуулж ажилласнаар сумдын ЗДТГ болон төрийн байгууллагууд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар төрийн байгууллагууд олон арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн зэрэг олон ажлыг дурдаж болно.

Хэрэглэгчийн үнэлгээний тайлантай танилцаж, байгууллагын вэб сайтыг шинэчилж, иргэд вэбсайтыг ашиглахад энгийн хялбар болгож, хүсэж буй үйлчилгээний талаарх мэдээллийг түргэн шуурхай авах нөхцөл боломжийг бүрдүүлж аймгийн цахим сайтын үйл ажиллагааг сайжруулж, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах арга хэмжээг тасралтгүй авч хэрэгжүүлж ажиллалаа.

Алтай сумын ИТХ, Засаг даргын Тамгын газар хийсэн ажлынхаа тайланг хөрөнгө санхүү төсөвлөхгүйгээр өөрсдийн дотоод нөөц бололцоогоо ашиглан хэвлэмэл сэтгүүл болон иргэд олон нийтэд мэдээлж ажиллаж байна.

Мөн Иргэдийн идвэх оролцоог нэмэгдүүлэх , мэдээлэл сургалт , сурталчилгааны үйл ажиллагааны үр дүн чанарыг сайжруулах үүднээс иргэддээ сард 2 удаа тогтмол өдөр, хугацаанд мэдээлэл хүргэх /236, 336/ гэсэн арга хэмжээг зохион байгуулж хэвшсэн байна.

Алтай сум нь сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сумын төвд Иргэний мэдээллийн төвийн байгуулсан.

Төгрөг сумын төвийн төсөвт байгууллагуудын дунд Байгууллага сурталчилах аяныг 2013 оноос хойш зохион байгуулж, жилийн эцэст Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн байр эзлүүлж урамшуулдаг.

/Эх сурвалж: Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн шийдвэр, гаргасан сэтгүүл зэрэг нотлох баримтыг тайланд хавсаргав./

Аймгийн Засаг дарга буюу төсвийн ерөнхийлөн захирагч 2016 онд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, 23 агентлагийн дарга, 18 сумын Засаг дарга, болон төсөвт байгууллагын /захирал, эрхлэгч/ дарга нартай гэрээ байгуулан ажиллаж хэрэгжилтийг тооцохдоо төсвийн сахилга батыг сайжруулах, талаар орон нутгийн удирдлагын зүгээс анхаарч үр дүнгийн гэрээг дүгнэхдээ гол үзүүлэлт болгож ажиллалаа.

Тайлант 2015 оны 11 дүгээр сарын 15-наас 2016 оны 11 дүгээр сарын 15-ны хугацаанд төсвийн зохистой удирдлага, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах хуульд заасан зарчмыг зөрчиж байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчил дутагдал гаргасан 7 төсвийн байгууллагын шууд захирагч нарт аймгийн Засаг даргын захирамжаар холбогдох хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл ногдууллаа.

2015 оны төсвийн жилийн ажлаар гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн тохиолдолд түүнийг урамшуулах, хариуцлага тооцох зэргээр Төсвийн сахилга батыг сайжруулах талаар орон нутгийн удирдлагын зүгээс санаачилгатай ажиллалаа.

/Эх сурвалж: аймгийн Засаг даргын захирамжийг тайланд хавсаргав./